

**БЭЛГИЙН ЗАМААР
ДАМЖИХ ХАЛДВАРЫН
ТАЛААРХ МЭДЛЭГЭЭ
НЭМЭГДҮҮЛЬЕ, ОХИД
БҮСГҮЙЧҮҮД МИНЬ**

Мэдээллийн багц-3



БЗДХ ГЭЖ ЮУ ВЭ?

**Бэлгийн
Замаар
Дамжих
Халдвар**

Халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орох үед дамжин халдварладаг өвчнүүдийг Бэлгийн Замаар Дамжих Халдвар (БЗДХ) гэнэ. Бэлгийн замаар дамжин халдварладаг 30 орчим өвчин байдаг.

Бэлгийн замын зонхилон тохиолдох халдварууд:

Тэмбүү

Заг хүйтэн

Трихомониаз

Хламид

Мөөгөнцөр

Нянгийн гаралтай
үтрээний үрэвсэл

Бэлгийн херпес

Бэлгийн үү

ДОХ

Вируст гепатит В, С

БЗДХ-ын үед илрэх шинж тэмдгүүд

Бэлэг эрхтэнээс хэвийн бус ялгадас гарах (хэмжээ ихэссэн, өнгөтэй, үнэртэй)

Бэлэг эрхтэн улайх, хавагнах

Бэлэг эрхтний орчмоор загатнах, хорсох

Бэлэг эрхтний орчим яр, шарх, цэврүү, үү гарах

Цавины булчирхай томрох

Хэрхэн илрүүлэх вэ?

Зөвхөн эмчийн үзлэг, шинжилгээгээр илрүүлнэ.

Шинжилгээнд судасны цус, наац (мазок) авна.

**Шинжилгээ, эмчилгээнд эрт хамрагдаагүй тохиолдолд
дараах хүндрэлүүд гарах боломжтой.**

Хүндрэл - Эмэгтэйчүүдэд

Хэвлийн доод хэсгээр байнга өвдөх

Умайн гадуур жирэмслэх

Үргүй болох

Үр аяндаа зулбах, дутуу төрөх

Өсөлтгүй жирэмсэн, ураг дотроо
амьгүй болох

Амьгүй хүүхэд төрүүлэх, хүүхэд амьд
төрсөн ч удалгүй нас барах

Умайн хүзүүний хорт хавдар үүсэх



Хүндрэл - Эрэгтэйчүүдэд

Шээсний сүв нарийсах

Үргүй болох

Бэлгийн сулрал

Төмсөг, түрүү булчирхай үрэвсэж
гэмтэх

Шээс задгайрах, шээс хаагдах,
тасалдах

Эмчлүүлэхэд юу анхаарах вэ?

Эмчийн заавраар

Цаг алдалгүй

Эрт эхэлж

Бүрэн төгс эмчилсэн тохиолдолд - **ҮР ДҮНТЭЙ.**

АНХААРАХ:

Эмийн санч болон найз нөхдийн заавраар өөрийгөө эмчлэх нь өвчин ужиг хэлбэрт шилжих, хүндрэлд хүргэх шалтгаан болдог.

Хэрвээ та доорх зөвлөгөөг дагаж чадвал өөрийгөө болон хайртыгаа, хэвлий дэх үрээ БЗДХ-аас сэргийлж чадна.

- Хосууд бие биедээ үнэнч байх
- Тохиолдлын бэлгийн хавьтлаас татгалзах, тэвчих
- Бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвчийг зөв, тогтмол хэрэглэх
- Архи, мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах
- Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний хяналтанд эрт хамрагдах
- БЗДХ-ын ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд мэргэжлийн эмчид хандах, хэрэв өвчин илэрвэл бэлгийн хавьтагчийн хамт цаг алдалгүй эмчлүүлэх

ТЭМБҮҮ ӨВЧИН

Тэмбүү өвчин нь нянгаар үүсдэг ба эмчлүүлээгүй тохиолдолд даамжирч олон эрхтэнг гэмтээдэг, жирэмсэн эхээс урагт дамжиж халдварладаг бэлгийн замын халдвар.

Халдвар дамжих замууд:



Тэмбүү өвчтэй хүнтэй
хамгаалалтгүй буюу
бэлгэвчгүйгээр бэлгийн
хавьталд орох үед

Халдварлагдсан цус, цусан
бүтээгдэхүүн, зүү тариур
хэрэглэх үед



Халдвартай жирэмсэн
эхээс урагт

Нууц хугацаа:

Халдвар авснаас хойш шинж тэмдэг илрэх хүртэл дунджаар 3-4 долоо хоног байна.



ТЭМБҮҮ өвчний үед шинж тэмдэг илрэхгүй байж болох уу?

Тэмбүү өвчний үед ямар нэгэн шинж тэмдэг илрэхгүй, гаднаасаа эрүүл хүн шиг харагдаж болно. Ийм үед зөвхөн цусны шинжилгээгээр халдвартай болох нь илэрдэг.

Илрэх шинж тэмдэг:

- Эрсдэлтэй бэлгийн хавьталд орсноос хойш дунджаар 21 хоногийн дараа бэлэг эрхтэн, түүний орчимд өвчин эмзэглэлгүй шарх (хатуу яр) гарна. Үүнийг анзаарахгүй өнгөрч болдог.
- Эмчилгээ хийлгээгүй ч гэсэн хатуу яр нь аяндаа алга болно.
- Тодорхой хугацааны дараа өвчин даамжирч арьс салстаар тархмал тууралт гарах, үс унах, арьс цайх шинж илэрнэ.
- Шарх гарснаас хойш ойролцоох тунгалгийн зангилаа буюу цавины булчирхай өвчин эмзэглэлгүй томорно.
- Халдвар авснаа мэдэхгүй, эрт оношлогдоогүй эсвэл эмчийн зааврын дагуу эмчилгээ хийлгээгүй, дутуу эмчлүүлсэн тохиолдолд өвчин хүндэрч 3-6 жилийн дараа арьс салст, эрхтэн тогтолцоог гүн гэмтээсэн (хамар унах, нүдний хараа муудах г.м) өөрчлөлт гарна. Мөн таны дотор эрхтэн, мэдрэлийн талаас ч гүнзгий өөрчлөлт илэрч яс, үе мөчийг гэмтээдэг.

БИ ЖИРЭМСЭН тэмбүү өвчин хүүхдэд минь халдах уу?

- Тэмбүүгийн халдвар авсан жирэмсэн эмэгтэй эмчлүүлээгүй тохиолдолд тэмбүү өвчин урагт халдварлана.
- Урагт халдварласнаас зулбах, дутуу төрөх, жин багатай, амьгүй хүүхэд төрөх, эсвэл төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрөх, нярай эндэх зэрэг хүндрэлд хүргэнэ.
- Иймээс, тээж буй хүүхдээ хамгаалахын тулд жирэмсний хугацаанд тэмбүүгийн шинжилгээнд 2 удаа хамрагдаж, “ЗЕРЭГ” гарсан тохиолдолд эмчлүүлэх нь зүйтэй.
- Хэрэв та эмчийн заавраар бүрэн төгс эмчилгээ хийлгэвэл хүүхдэд халдвар дамжихгүй байж болно.



Тэмбүүгийн халдвар авснаа хэрхэн мэдэх вэ?

Тэмбүүгийн халдвар илрүүлэх цусны шинжилгээ хийлгэнэ. Хариу **“СӨРӨГ”** байх нь халдваргүй, **“ЗЕРЭГ”** байх нь тэмбүүгийн халдвартай гэсэн үг.

Тэмбүү өвчнийг гүйцэд эмчилж болох уу?

БОЛНО. Мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээгээ бүрэн хийлгэвэл төгс эмчлэгдэнэ.

Би тэмбүү өвчин тусгаад эмчлэгдсэн. Дахиж энэ өвчнөөр өвчлөх үү?

Та халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орвол дахин өвчилнө. Та өөрөө



бүрэн гүйцэд эмчлүүлсэн ч таны бэлгийн хавьтагч эмчлүүлээгүй бол та дахин халдвар авна.

Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэлт гэж юу вэ?

Бүсгүй та эрсдэлд орсны дараа 72 цагийн дотор “Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэлт”-ийн цомгийн эмийн эмчилгээнд хамрагдсанаар ТЭМБҮҮ өвчний халдвар авахаас, мөн ХҮСЭЭГҮЙ ЖИРЭМСЛЭЛТ-ээс бүрэн сэргийлэх боломжтой.

Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэх эмийг хаанаас авах вэ?

“Төгс бүсгүйчүүд” ТББ, дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлээс авах боломжтой.

ЗАГ ХҮЙТЭН ӨВЧИН

Заг хүйтэн өвчин нь нянгаар үүсгэгддэг бэлгийн замын халдвар юм.

Халдвар дамжих замууд

- Халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орох үед
- Халдвартай жирэмсэн эхээс төрөх явцад, мөн хүүхдээ асрах үед нярайд халдвар дамжина.

Нууц хугацаа

Халдвар авснаас хойш шинж тэмдэг илрэх хүртэл эрэгтэй хүнд 3-5 хоног, эмэгтэй хүнд 5-10 хоног байна.

Илрэх шинж тэмдэг

Эмэгтэйчүүдэд ихэвчлэн шинж тэмдэггүй, эсвэл бүдэг балархай хэлбэрээр тохиолдоно. Зарим тохиолдолд бэлэг эрхтэн орчим эвгүй оргих, загатнах зовиур илэрч, умайн хүзүүний сувгаас бага хэмжээний салсархаг-идээрхэг ялгадас гарна.

Эрэгтэйчүүдийн 90-95%-д шинж тэмдэг хурц илэрнэ. Энэ үед шээсний сүв хорсох, шээхэд өвдөх зовиур илрэх ба шээсний сүвнээс шар ногоон өтгөн идээ гарч, шээсний сүв улайж хавагнан үрэвсэнэ.

Хүндрэл, үр дагавар

- Эмэгтэйчүүдэд умай, умайн гуурсан хоолой, өндгөвч зэрэг аарцгийн хөндийн эрхтний үрэвсэлт өвчин үүсч **ҮРГҮЙДЭЛ, УМАЙН ГАДУУРХ ЖИРЭМСЛЭЛТ** зэрэг хүндрэл үүсгэдэг.
- Заг хүйтэн өвчин нь эмчилгээ хийлгээгүй тохиолдолд эрэгтэйчүүдэд төмсөг, төмсөгний дайвар, түрүү булчирхайн үрэвсэл үүсгэх ба **ҮРГҮЙДЭЛ**-д хүргэдэг.

Заг хүйтэн өвчний гаралтай нярайн нүдний салстын үрэвсэл

Заг хүйтэн өвчтэй жирэмсэн эмэгтэйгээс төрөх үед нярайд халдвар дамжиж нярайн нүдний салстын үрэвсэл үүсгэнэ. Халдвар богино хугацаанд нүдний эвэрлэгийг гэмтээн шарх үүсгэж, COXPOX аюулд хүргэх учир яаралтай эмчилгээ хийлгэх хэрэгтэй.



Заг хүйтэн өвчнийг гүйцэд эмчилж болох уу?

БОЛНО. Мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээгээ бүрэн хийлгэвэл төгс эмчлэгдэнэ.

Би заг хүйтэн өвчин тусгаад эмчлэгдсэн. Дахиж энэ өвчнөөр өвчлөх үү?

Та халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орвол дахин өвдөнө. Та өөрөө бүрэн гүйцэд эмчлүүлсэн ч таны бэлгийн хавьтагч эмчлүүлээгүй бол та дахин халдвар авна.

Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэлт гэж юу вэ?

Бүсгүй та эрсдэлд орсны дараа 72 цагийн дотор “Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэлт”-ийн цомгийн эмийн эмчилгээнд хамрагдсанаар ЗАГ ХҮЙТЭН өвчний халдвар авахаас, мөн ХҮСЭЭГҮЙ ЖИРЭМСЛЭЛТ-ээс бүрэн сэргийлэх боломжтой.

Өртөлтийн дараах урьдчилан сэргийлэх эмийг хаанаас авах вэ?

“Төгс бүсгүйчүүд” ТББ, дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлээс авах боломжтой.

ШЭЭС БЭЛГИЙН ЗАМЫН ХЛАМИДИЙН ХАЛДВАР

Хламидийн халдвар нь нянгаар үүсгэгддэг бэлгийн замын халдвар юм.

Халдвар дамжих замууд

- Халдвартай хүнтэй хамгаалалтгүй(бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орох үед

БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ТАЛААРХ МЭДЛЭГЭЭ НЭМЭГДҮҮЛЬЕ, ОХИД БҮСГҮЙЧҮҮД МИНЬ

- Хламидийн халдвартай жирэмсэн эхээс төрөх үед нярайд халдвар дамжина.

Нууц хугацаа

Халдвар авснаас хойш шинж тэмдэг илрэх хүртэл дунджаар 10-15 хоног байна.

Илрэх шинж тэмдэг

- Эмэгтэйчүүдийн 70%-д шинж тэмдэггүй, балархай хэлбэрээр тохиолдоно.
- Зарим өвчтөнд гадна бэлэг эрхтэн загатнах, бэлгийн хавьтлын үед өвдөх, хэвлийн доод хэсгээр өвдөх зовиур илрэх ба умайн хүзүүнээс бага зэрэг салсархаг, салсархаг-идээрхэг ялгадас гарна.
- Эрэгтэйчүүдийн 50%-д ямар нэг шинж тэмдэг илрэхгүй байж болно. Шээхэд бага зэрэг ирвэгнэх, хорсох зовиур илэрч, шээсний сүв улайх, хавагнах ба шээсний сүвнээс салсархаг ялгадас бага зэрэг гарах шинж тэмдэг илэрнэ.

Хүндрэл, үр дагавар

- Эмэгтэйчүүдэд умай, умайн гуурсан хоолой, өндгөвч зэрэг аарцгийн хөндийн эрхтний үрэвсэлт өвчнүүд үүссэний улмаас **ҮРГҮЙДЭЛ, УМАЙН ГАДУУРХ ЖИРЭМСЛЭЛТ** зэрэг хүндрэлд хүргэж болно.
- Эрэгтэйчүүдэд төмсөг, төмсөгний дайвар ба түрүү булчирхайн үрэвсэл үүсгэж улмаар **ҮРГҮЙДЭЛ**-д хүргэнэ.



Хламидийн халдварын гаралтай нярайн нүдний салстын үрэвсэл

Хламидийн халдвартай жирэмсэн эмэгтэйгээс төрөх үед нярайд халдвар дамжиж, нярайн нүдний салстын үрэвсэл, уушигны хатгаа үүсгэнэ.

ТРИХОМОНИАЗ ӨВЧИН

Трихомониаз өвчин нь шимэгчээр үүсгэгддэг бэлгийн замын халдвар юм.

Халдвар дамжих замууд

Халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орсон тохиолдолд халдварлана.

Нууц хугацаа

Халдвар авснаас хойш шинж тэмдэг илрэх хүртэл дунджаар 10-15 хоног байна.

Илрэх шинж тэмдэг

- Эмэгтэйчүүдэд бэлэг эрхтэн орчим загатнаж хорсох зовиур илэрч, үтрээнээс их хэмжээний шингэн, ногоовтор буюу шаргал өнгийн хөөсөрхөг ялгас гарна. Зарим тохиолдолд шинж тэмдэг илрэхгүй боловч үе үе бэлэг эрхтэн орчим загатнах, үтрээнээс бага зэрэг ялгас гарах зэрэг зовиур, шинж тэмдэг илэрч болно.
- Эрэгтэйчүүдэд ихэвчлэн шинж тэмдэггүй явагддаг ба ховор тохиолдолд шээхэд хорсох, өвдөх, загатнах, бэлгийн хавьтлын дараа хорсох зэрэг зовиур илэрч, шээсний сувгаас бага зэрэг салсархаг ялгас гардаг.

ШЭЭС БЭЛГИЙН ЗАМЫН МӨӨГӨНЦӨР ӨВЧИН

Шээс бэлгийн замын мөөгөнцрийн үед шээс бэлгийн замын эрхтнүүд хөрөнгө төст мөөгөнцрөөр гэмтдэг. Дархлаа суларсан, чихрийн шижин өвчтэй, жирэмснээс хамгаалах эм, антибиотик хэрэглэсэн үед мөн жирэмсэн эмэгтэйчүүдэд элбэг тохиолддог, архаг явцтай, дахилт өгдөг өвчин.

Илрэх шинж тэмдэг

- Эмэгтэйчүүдэд бэлэг эрхтэн орчим загатнах, хорсох зовиур илэрч, үтрээнээс өтгөн, цагаан ээдэмцэр маягийн ялгадас их хэмжээтэй гарна. Мөн бэлгийн уруул болон үтрээний салст улайж хавагнан үрэвсэл үүсдэг.
- Эрэгтэйчүүдэд бэлэг эрхтэн орчим загатнах, ирвэгнэх, хорсох зовиур илэрч, тээрхий болон шамрангийн дотор талын салст бага зэрэг улайж, жижиг гүвдрүүн тууралт гарна, зарим тохиолдолд цайвар саарал өнгөрөөр хучигддаг.

НЯНГИЙН ГАРАЛТАЙ ҮТРЭЭНИЙ ҮРЭВСЭЛ

Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл нь үтрээн дэх хэвийн бичил биетний тоо багасч, бусад агааргүйтэн нян давамгайлж үтрээний нянгийн тэнцвэрт байдал алдагдсанаас шалтгаалан эмгэг шинжээр илэрдэг үрэвсэл юм.

Илрэх шинж тэмдэг

- Загатнах, хорсох, бэлгийн хавьтлын үед хорсож өвдөх зэрэг зовиур илэрч, үтрээнээс цайвар саарал өнгийн наалдамхай, ялзарсан загас мэт эвгүй үнэртэй ялгадас гарна.



**Хэрэв ТА өөрийгөө БЗДХ авах эрсдэл
бүхий алхам хийсэн гэж бодож байгаа
бол хугацаа алдахгүйгээр шинжилгээ өгч,
эмчийн зааврын дагуу эмчилгээг бүрэн төгс
хийлгэвэл үр дүн сайтай.**





Төрийн бус байгууллага

БЗД 18-р хороо “Шинэ зуун” хотхон
24г-22 тоот
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:77055390
www.tugsbuichuud.mn

ЭМЯ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүгийн
дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.